



**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/448

Улаанбаатар хот

「Бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах тухай」

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 31 дүгээр зүйлийн 31.1.7 дахь заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.5 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 63 дугаар тогтоол, 2012 оны 61 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Шинэ жилийн баяр”-ыг угтан дүүргийн нутаг дэвсгэрт Бүх нийтийн их цэвэрлэгээг 2017 оны 12 дугаар сарын 22, 23-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Бүх нийтийн их цэвэрлэгээнд хяналт тавих ажлын хэсгийг нэгдүгээр, хороод, аж ахуйн нэгж, байгууллагын цэвэрлэгээ хийх хуваарь удирдамжийг хоёр дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах, хуримтлагдсан хог хаягдлыг шуурхай тээвэрлүүлэн ажиллахыг Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс /Б.Отгонхүү/, Нийтлэг үйлчилгээний газар-1, 2, 3, 4 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар /Ж.Мөнх-Од, Д.Нэргүй, Х.Өлзийхорол, Э.Хатанбаатар/-т, бүх нийтийн цэвэрлэгээг хорооны нутаг дэвсгэрт зохион байгуулж аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг өргөнөөр хамруулж ажиллахыг хороодын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Цэвэрлэгээ хангалтгүй хийсэн газруудад хяналт тавьж, холбогдох хуулийн дагуу захиргааны арга хэмжээ авч ажиллахыг Төрийн Захиргааны удирдлагын хэлтэс /А.Пүрэвдулам/, Дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс /Д.Цэнд-Очир/-т тус тус даалгасугай.

5. Цэвэрлэгээний ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан ажиллахыг, Хэвлэл мэдээллийн алба /Д.Цэнгэлмаа/-д даалгасугай.

6. Цэвэрлэгээний ажилд аж ахуйн нэгж, байгууллагуудыг өргөнөөр оролцуулах, хяналт тавих, мэдээг нэгтгэж дутагдалтай ажилласан хороо, байгууллага, аж ахуйн нэгжид авах арга хэмжээний санал боловсруулж танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Т.Батцогт/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Т.БАЯСАХ